



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/143/СТА-ТШЗ

Цахим хуудас: [Bayankhongor@  
audit.gov.mn](mailto:Bayankhongor@audit.gov.mn)

Баянхонгор хот  
2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: [tseenyama@audit.gov.mn](mailto:tseenyama@audit.gov.mn)

Аудитор: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

<b>Аудитын гэрчилгээ</b> .....	<b>3</b>
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
<b>Аудит хийгдсэн санхүүгийн тайлан</b> .....	<b>11</b>
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	19
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	22



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ  
СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА Л.БАТХУЯГ  
ТАНАА

Ауд. ос. д.т № 1/174

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4  
005020124

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

## **Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Тамгын газрын дарга Л.Батхуяг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-наас 2020 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Цэцэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 25-ний өдөр 2019 оны 12 дугаар сарын 12-ны 130 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ нь тайлант хугацаанд Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, хууль тогтоомжийг сурталчлан хэрэгжүүлж, орон нутгийн хөгжлийг дээшлүүлэх зорилгоор 2019 оныг “Төрийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх” болгох эрхэм зорилгын хүрээнд зорилтуудаа дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ний Acolous программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 35 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

#### **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 751772,6 мянган төгрөгөөс 2,0 хувиар тооцон 15035,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 15035,4 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурь, материаллаг байдлыг тооцох хувийг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 170719,3 мянган төгрөгөөр буюу 5,7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0,0	0,0	0
Авлага	4424,9	0,00	-4424,90
Урьдчилгаа	0,0	0,0	0,0
Бараа материал	102670,3	130492,5	27822,2
Үндсэн хөрөнгө	3803695,7	3885219,6	81523,9
Үндсэн хөрөнгийн элэгдэл	-902671,6	-1072412,1	-169740,5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3008119,3</b>	<b>2943299,6</b>	<b>-64819,7</b>
Өр төлбөр	216,1	0,0	216,1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3007903,2	2943299,6	64819,7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3008119,3</b>	<b>2943299,6</b>	<b>64819,7</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 27822,2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 40502,9 мянган төгрөгийн худалдан авалт хийж, бусад эх үүсвэрээс 101094,8 мянган төгрөгийн буюу нийт 141597,7 мянган төгрөгөөр бараа материал нэмэгдэж, 113775,6 мянган төгрөгийн зарцуулалт гарснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд өмнөх онуудад худалдаж авсан ашиглалтгүй нөөцөлсөн бараа материал байхгүй байна. Бусад эх үүсвэрээр нэмэгдсэн бараа материал нь ОНХС-гийн эх үүсвэрээр бэлтгэгдсэн өвс, тэжээл, малжуулах төслийн малыг орлогод авсантай холбоотой байна. Өмнөх оны эцэст байсан авлагыг барагдуулж, тайлант онд шинээр авлага үүсээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 81523,9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 13748,6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, ОНХС-гийн болон бусад эх үүсвэрээс 242091,8 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, эрх бүхий байгууллагын шийдвэрээр 174316,5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

Үнэ төлбөргүй шилжүүлсэн үндсэн хөрөнгө байхгүй, акталсан 174316,5 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө хасагдсан байна.

Биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2837400,0 мянган төгрөг болж 170503,2 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга гараагүй.

## **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар тайлант онд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө байхгүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 340032.2 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 339432,2 орон нутгийн төсвөөс , 600,0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан авч үзвэл орон нутгийн төсвөөс 339432,2 мянган төгрөгийн санхүүжилт авах төлөвлөгөө батлагдсаныг бүрэн авч , туслах үйл ажиллагааны орлогоос 688,6 мянган төгрөгийг оруулж, 332360,7 мянган төгрөгийг зарцуулан 7671,7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй харьцуулан дүн шинжилгээ хийхэд батлагдсан төсвийг бүрэн авч зарцуулсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төсөв батлагдаагүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 332360,7 мянган төгрөг буюу 97,7 хувьтай байна.

**Нэмэлт төсөв:** Төсөл, хөтөлбөрөөр хамтарсан багийн ажлын санхүүжилтээр ГБХЗХГ-аас 2000,0 мянга, үндсэн бус үйл ажиллагааны хүрээнд тендерийн баримт бичгийн үнэ 469,0 мянган, татан төвлөрүүлсэн нэмэлт санхүүжилтийг буцаан олгосны орлого 1194,9 мянган, нийт 3861,9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 2594,0 мянган төгрөгийг зарцуулан 1267,9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Үүнээс урсгал зардалд нийт 2594,0 мянган төгрөгийг зарцуулжээ.

## **2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 35 эрсдэл тодорхойлж , гүйцэтгэлийн шатанд нийт 35 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 16355,6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1309,7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 заалт бүхий зөвлөмж өгч, 15045,9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

**Илрүүлэлт:** Горим сорилыг хэрэгжүүлэх явцад Сумын Засаг дарга О.Мөнхтөрийн 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Б/03 тоот захирамжаар

ажлаас чөлөөлөгдсөн ЗДТГ-ын дарга Л.Батхуягт Баянхонгор аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 09-ний 111/ШШ2017/0036 тоот шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт ЗДТГ-ын 2019 оны төсвөөс 11045,9 мянган төгрөгийг, ЗДТГ-ын дарга асан Д.Амарсайханы 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Б/01 тоот тушаалаар ажлаас халагдсан Байгаль орчны байцаагчаар ажиллаж байсан Ш.Бямбацогоод Баянхонгор аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 111/ШШ2018/0016 тоот шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт ЗДТГ-ын 2019 оны төсвөөс 4000,0 мянган төгрөгийг тус тус бусад урсгал шилжүүлгийн зардлаас олгож буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

### Эрсдэл

Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, төсөвт хохирол учруулах

### Шийдвэрлэсэн нь:

Зөрчлийг арилгах арга хэмжээ авах албан шаардлагыг Дотоод хяналт, аудитын албаны даргад хүргүүлэв.

## **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Байхгүй

## **2.13. Шилэн дансны мэдээлэл**

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байршуулах үүрэгтэй.

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	6	3	2
2	Хагас жил	4	4	2	2	
3	Улирал бүр	1	4	3	1	
4	Сар бүр	3	36	24	12	
	Тухай бүр	8	96	69	27	
	Нийт	27	151	104	45	2

## **2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 7607,1 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтахгүй байх 2 заалт бүхий зөвлөмж өгснийг давтан шалгахад 80,0%-ийн хэрэгжилттэй гэж үнэлэгдсэн байна. Зөвлөмжийн биелэлтийг ЗДТГ-ын 2019 оны 06-р сарын 17-ны өдрийн 79 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### “Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## **Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

*Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:*

### **1. Орлого , эх үүсвэрийн бүртгэл**

#### **Илрүүлэлт**

1.1. Тайлант хугацаанд ОНХС-гийн хөрөнгөөр бэлтгэгдсэн 49990,0 мянган төгрөгийн үнэтэй Ковш тракторыг 49900,0 мянган төгрөгөөр буюу 90,0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн Үнэлгээ, Хэмжилт, Топилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Эрсдэл**

Хөрөнгө дутуу үнэлэгдсэнээр Засгийн газрын сан буруу илэрхийлэгдэх

#### **Өгсөн зөвлөмж:**

Үнийн зөрүүг 2020 оны 1-р улирлын санхүүгийн тайланд залруулан нэмж бүртгэх

#### **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Зөвшөөрсөн.

### **2.Төсөв , гүйцэтгэлтэй холбоотой асуудал :**

#### **Илрүүлэлт**

1. Цалингийн зардлын давтан тооцооллоор авлага, өглөгийн үлдэгдэл зөрүүгүй тохирч байгаа боловч татварын тайлангаар эцсийн үлдэгдэл 813,0 мянган төгрөг, НДШ төлөлтийн тайлангаар оны эцэст 406,8 мянган төгрөгийн тус тус илүү төлөлттэй гарсан байна. Дээрх 406,7 мянган төгрөг нь Шүүхийн шийдвэрээр 1 ажилтанд олгох нөхөн олговор бүрэн олгогдоогүй тул НДХ мэдээнд шивж оруулаагүйтэй холбоотой боловч үүнийг ЗДТГ нь авлагаар бүртгээгүй, НДХ-т

мэдээлээгүй байгаа нь **Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга** батламж мэдэгдлийг хангахгүй байна

**Эрсдэл**

Өглөг, авлага зөрүүтэй илэрхийлэгдэх, хууль, тогтоомж зөрчигдөх

**Өгсөн зөвлөмж:**

1. Шүүхийн шийдвэрээр олгогдсон ажилтны цалинг НД-ын байгууллагад нөхөн мэдээлэх, татварын байгууллагатай өмнөх оны суутган татварын тооцоог дахин хийж өглөг, авлагын үлдэгдлийг баталгаажуулах

**Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Зөвшөөрсөн.

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, гарсан үр дүнгийн талаар төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хариу ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-1А

#### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>107,095,197.94</u></b>	<b><u>130,492,443.64</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	92,670,314.00	120,492,443.64
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	39,996,734.00	41,096,734.00
35110	Тусгай зориулалттай материал	39,996,734.00	41,096,734.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	30,871,000.00	21,985,829.64
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	7,186,580.00	7,793,880.00
35410	Бичиг хэргийн материал	1,589,250.00	1,904,250.00
35420	Аж ахуйн материал	3,453,180.00	3,745,480.00
35470	Бусад хангамжийн материал	2,144,150.00	2,144,150.00
35600	Мал амьтад	14,616,000.00	49,616,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	10,000,000.00	10,000,000.00
36600	Бусад нөөц	10,000,000.00	10,000,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,901,024,167.63</u></b>	<b><u>2,812,807,520.77</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,901,024,167.63	2,812,807,520.77
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,764,286,167.63	2,676,069,520.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,163,389,248.00	3,054,343,463.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-590,476,127.08	-753,888,949.30
39203	Авто-тээврийн хэрэгсэл	137,042,385.00	215,142,385.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-87,124,325.02	-96,632,533.58
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	194,009,387.50	174,060,455.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-155,976,321.69	-141,162,785.99
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57,643,744.00	63,411,544.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-30,964,239.70	-36,064,896.89
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	4,926,000.00	4,841,000.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	-1,637,233.19	-2,565,766.67
39214	Бусад үндсэн хөрөнгө	109,347,018.13	235,949,376.13
39215	Хуримтлагдсан элэгдэл	-35,893,368.32	-41,497,170.43
39217	Ном	00.00	133,400.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	136,738,000.00	136,738,000.00

**Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

39301	Програм хангамж	600,000.00	600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-600,000.00	-600,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	136,738,000.00	136,738,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,008,119,365.57</u></b>	<b><u>2,943,299,964.41</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>3,007,903,237.57</u></b>	<b><u>2,943,299,964.41</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,007,903,237.57	2,943,299,964.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	684,879,255.00	684,879,255.00
51101	Өмч: - төрийн	684,879,255.00	684,879,255.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,475,107,134.38	1,410,503,861.22
51210	Өмнөх үеийн үр дүн	1,475,107,134.38	1,475,107,134.38
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-64,603,273.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	847,916,848.19	847,916,848.19
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>3,008,119,365.57</u></b>	<b><u>2,943,299,964.41</u></b>

#### 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
СТ-2А

#### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>567,802,864.30</b>	<b>687,169,366.44</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>215,504,636.80</b>	<b>343,875,236.44</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	215,504,636.80	343,875,236.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	215,504,636.80	343,875,236.44
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	165,000.00	688,620.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	215,339,636.80	343,186,616.44
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>352,298,227.50</b>	<b>343,294,130.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	19,904,680.00	3,861,930.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,904,680.00	3,861,930.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	331,162,356.50	339,432,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	331,162,356.50	339,432,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,231,191.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,231,191.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>471,291,933.25</b>	<b>535,436,220.60</b>

**Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>471,291,933.25</b>	<b>535,436,220.60</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	427,723,584.23	497,538,564.61
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	175,796,478.12	188,600,254.00
210101	Үндсэн цалин	149,784,132.12	188,600,254.00
210102	Нэмэгдэл	4,836,798.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	21,175,548.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	17,591,979.36	23,778,317.95
210201	Тэтгэврийн даатгал	13,579,005.00	16,128,497.33
210202	Тэтгэмжийн даатгал	888,755.00	1,913,559.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	636,338.00	1,534,499.38
210204	Ажилгүйдлийн даатгал	662,626.00	365,463.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,825,255.36	3,836,299.24
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	14,651,293.00	15,651,571.00
210301	Гэрэл, цахилгаан	1,641,435.00	1,706,971.00
210302	Түлш, халаалт	13,009,858.00	13,944,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,117,370.01	26,166,650.00
210401	Бичиг хэрэг	3,247,050.00	3,318,570.00
210402	Тээвэр, шатахуун	12,664,020.01	16,899,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,709,000.00	3,564,000.00
210404	Ном, хэвлэл	375,000.00	1,380,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	92,300.00	1,004,600.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	30,000.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	422,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	422,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	525,000.00	11,233,400.00
210604	Урсгал засвар	525,000.00	11,233,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,627,990.00	8,437,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	1,000,000.00
210702	Дотоод албан томилолт	6,627,990.00	7,437,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	20,313,898.00	12,154,907.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,253,930.00	10,378,835.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	124,800.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	453,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	359,375.00	370,580.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,305.00	130,000.00
210807	Газрын төлбөр	62,488.00	525,492.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	173,677,575.74	211,516,464.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,646,200.00	4,803,150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	158,300.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	168,873,075.74	206,713,314.66
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	43,568,349.02	37,897,655.99
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	34,200,000.00	00.00

**Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	34,200,000.00	00.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,585,717.00</b>	<b>28,869,649.00</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,505,717.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	12,045,894.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	16,376,255.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,080,000.00	447,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>5,782,632.02</b>	<b>7,760,076.99</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,782,632.02	7,760,076.99
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>1,267,930.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,267,930.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>96,510,931.05</b>	<b>151,733,145.84</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>84,447,646.17</b>	<b>216,336,419.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,702,565.97	137,343,737.20
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	58,040,500.00	78,992,681.80
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	23,704,580.20	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-84,447,646.17</b>	<b>-216,336,419.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>12,063,284.88</b>	<b>-64,603,273.16</b>

**4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
СТ-2А

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>352,264,612.50</b>	<b>343,982,750.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>186,030.00</b>	<b>688,620.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>186,030.00</b>	<b>688,620.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	186,030.00	688,620.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	186,030.00	688,620.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>352,078,582.50</b>	<b>343,294,130.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>19,904,680.00</b>	<b>3,861,930.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,904,680.00	3,861,930.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>329,668,185.50</b>	<b>339,432,200.00</b>

**Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	329,668,185.50	339,432,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	2,505,717.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,505,717.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>352,264,612.50</b>	<b>330,234,150.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>352,264,612.50</b>	<b>330,234,150.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>276,241,963.48</b>	<b>292,031,509.01</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	175,694,478.12	188,397,710.39
210101	Үндсэн цалин	148,626,073.12	188,397,710.39
210102	Нэмэгдэл	4,836,798.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	22,231,607.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	17,591,979.36	23,772,120.62
210201	Тэтгэврийн даатгал	14,097,044.00	16,122,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	897,491.36	1,913,559.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	627,954.00	1,534,499.38
210204	Ажилгүйдлийн даатгал	61,746.00	365,463.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,907,744.00	3,836,299.24
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	14,651,293.00	15,651,571.00
210301	Гэрэл, цахилгаан	1,641,435.00	1,706,971.00
210302	Түлш, халаалт	13,009,858.00	13,944,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	19,177,310.00	26,221,250.00
210401	Бичиг хэрэг	3,100,610.00	3,378,570.00
210402	Тээвэр, шатахуун	13,870,400.00	16,899,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,709,000.00	3,564,000.00
210404	Ном, хэвлэл	375,000.00	1,380,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	122,300.00	999,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	422,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	422,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,848,000.00	11,413,400.00
210602	Тавилга	2,300,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,548,000.00	11,413,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,627,990.00	8,437,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	1,000,000.00
210702	Дотоод албан томилолт	6,627,990.00	7,437,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	32,319,013.00	12,159,107.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,326,420.00	10,383,035.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	124,800.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	453,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	292,000.00	370,580.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,305.00	130,000.00
210807	Газрын төлбөр	62,488.00	525,492.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,909,900.00	5,979,350.00

**Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,396,200.00	5,979,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	513,700.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>76,022,649.02</b>	<b>38,202,640.99</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	66,654,300.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	66,654,300.00	00.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,585,717.00	29,174,634.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,505,717.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	12,225,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	16,501,434.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,080,000.00	447,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	4,587,702.02	7,760,076.99
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,587,702.02	7,760,076.99
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,194,930.00	1,267,930.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,194,930.00	1,267,930.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>13,748,600.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>13,748,600.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>13,748,600.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	13,748,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	13,748,600.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-13,748,600.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

**4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
СТ-4А

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	-------	---

**Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	585,141,255.00	339,321,070.00	1,466,058,205.70	00.00	2,390,520,530.70
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	585,141,255.00	339,321,070.00	1,466,058,205.70	00.00	2,390,520,530.70
C07	Тайлант үеийн үр дүн	99,738,000.00	00.00	12,063,284.88	00.00	111,801,284.88
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	684,879,255.00	847,916,848.19	1,475,107,134.38	00.00	3,007,903,237.57
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	684,879,255.00	847,916,848.19	1,475,107,134.38	00.00	3,007,903,237.57
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	684,879,255.00	847,916,848.19	1,475,107,134.38	00.00	3,007,903,237.57
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-64,603,273.16	00.00	-64,603,273.16
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	684,879,255.00	847,916,848.19	1,410,503,861.22	00.00	2,943,299,964.41

**4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	312,391,897.00	278,856,259.00	340,032,200.00	332,360,743.01
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	312,391,897.00	278,856,259.00	340,032,200.00	332,360,743.01
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	283,501,697.00	253,035,968.00	310,206,500.00	303,186,109.01
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	179,224,440.00	172,821,577.00	191,714,700.00	188,397,710.39
210101	Үндсэн цалин	160,947,020.00	153,876,634.00	191,714,700.00	188,397,710.39
210105	Гэрээт ажлын хөлс	18,277,420.00	18,944,943.00	00.00	00.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	19,614,100.00	19,440,264.00	23,794,800.00	23,772,120.62
210201	Тэтгэврийн даатгал	19,614,100.00	19,440,264.00	16,122,300.00	16,122,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	1,918,100.00	1,913,559.00

**Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	1,534,500.00	1,534,499.38
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	383,600.00	365,463.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	3,836,300.00	3,836,299.24
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	8,659,457.00	10,997,364.00	15,824,600.00	15,651,571.00
210301	Гэрэл, цахилгаан	2,959,457.00	2,243,364.00	1,880,000.00	1,706,971.00
210302	Түлш, халаалт	5,700,000.00	8,754,000.00	13,944,600.00	13,944,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,684,650.00	17,141,778.00	26,442,800.00	26,221,250.00
210401	Бичиг хэрэг	3,250,000.00	2,082,680.00	3,598,100.00	3,378,570.00
210402	Тээвэр, шатахуун	18,107,050.00	13,424,498.00	16,900,000.00	16,899,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,724,600.00	1,458,600.00	3,564,000.00	3,564,000.00
210404	Ном, хэвлэл	1,603,000.00	176,000.00	1,380,700.00	1,380,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	00.00	1,000,000.00	999,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	800,000.00	800,000.00	00.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00	00.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	15,012,456.00	9,692,000.00	25,400,000.00	25,028,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,175,400.00	3,592,000.00	00.00	00.00
210602	Тавилга	00.00	6,100,000.00	10,000,000.00	9,985,200.00
210604	Урсгал засвар	3,837,056.00	00.00	15,400,000.00	15,043,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	10,798,400.00	7,314,500.00	8,552,600.00	8,437,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00	1,000,000.00	1,000,000.00
210702	Дотоод албан томилолт	10,798,400.00	7,314,500.00	7,552,600.00	7,437,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,132,644.00	2,458,675.00	11,543,000.00	9,698,507.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,864,844.00	2,201,995.00	9,500,000.00	7,922,435.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	250,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	00.00	500,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	235,800.00	224,680.00	410,000.00	370,580.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	00.00	190,000.00	130,000.00

**Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210807	Газрын төлбөр	32,000.00	32,000.00	693,000.00	525,492.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	17575550.00	12369810.00	6934000.00	5979350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,671,050.00	12,169,810.00	6,724,000.00	5,979,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,904,500.00	200,000.00	210,000.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	28890200.00	25820291.00	29825700.00	29174634.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	28,890,200.00	25,820,291.00	29,825,700.00	29,174,634.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	764,200.00	764,500.00	12,225,700.00	12,225,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,326,000.00	25,055,791.00	00.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	00.00	16,600,000.00	16,501,434.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	600,000.00	00.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	00.00	1,000,000.00	447,500.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	267,096,577.00	265,533,838.00	340,032,200.00	332,360,743.01
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	246,372,200.00	248,339,600.00	339,432,200.00	331,672,123.01
132001	Орон нутгийн төсвөөс	246,372,200.00	248,339,600.00	339,432,200.00	331,672,123.01
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	20,724,377.00	13,652,578.00	600,000.00	688,620.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,724,377.00	13,562,578.00	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	90,000.00	600,000.00	688,620.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	01	01	01	01
610001	Төсвийн байгууллага	01	01	01	01
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	21	21	21	21
620001	Удирдах ажилтан	06	06	06	06
620002	Гүйцэтгэх ажилтан	12	12	12	12
620003	Үйлчлэх ажилтан	03	03	03	03

**Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>21</b>	<b>21</b>	<b>21</b>	<b>21</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	06	06	06	06
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	06	06	06	06
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	03	03	03	03
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	06	06	06	06

**4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>18709750.00</b>	<b>2,594,000.00</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	18709750.00	2594000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18709750.00	2,594,000.00

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

БЭЛТГЭСЭН: ГЭРЭЭТ АУДИТОР

Д.ЦЭЦЭГМАА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

Огноо: 2020.02.27